



2012 оны 11 сарын 16
(4-р хэвлэл)

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ И-СОНИН

Лондонгийн хөрөнгийн биржийн Академийн сургалт 2013 оны 1-р сарын 14-18-ны өдрүүдэд Лондон хотноо зохиогдоно.

”Монголын хөрөнгийн бирж нь Лондонгийн хөрөнгийн биржийн Академи (ЛХБ Академи) сургалтын төвтэй хамтран 2011 оны 6-8 саруудад Хөрөнгийн зах зээлийн хоёр шатлалт сургалтыг Улаанбаатар болон Лондон хотноо амжилттай зохион байгуулсан билээ.

Хөрөнгийн зах зээлийн мэргэжилтнүүдийн сургалтын хэрэгцээ, шаардлагыг харгалзан үзэж, хөрөнгийн зах зээлийн дараагийн шатны сургалтыг Монголын хөрөнгийн биржээс ЛХБ Академитэй хамтран 2013 оны 1-р сарын 14-18-ны өдрүүдэд Лондон хотноо зохион байгуулах гэж байна.

Тус сургалтанд Компанийн үнэлгээ, Бонд, тогтмол хүү төлөгч үнэт цаас, үүсмэл үнэт цаас зэрэг чухал сэдвүүдийг ЛХБ Академийн мэргэжилтэн багш нар заах бөгөөд энэхүү сургалтанд хөрөнгийн зах зээлийн оролцогч байгууллагын төлөөлөл болсон 30 хүртэлх мэргэжилтнүүд оролцох боломжтой.

Дэлгэрэнгүй мэдээллийг МХБ-ийн цахим хуудас /www.mse.mn/-ээс авна уу.

”Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгалаа.

Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 11-р сарын 7-ны өдрийн 322 тоот тогтоолоор ”Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай” хуулийн 6.1.3, 6.2.2, ”Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 6.2, 10.1.5 дэх заалтуудыг тус тус үндэслэн ”Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатайгаар сунгалаа.


Арилжаанд оролцох эрхтэй компаниудын тоо 51-д хүрлээ.

Төлбөрийн баталгааны санд хөрөнгө байршуулсан 57 компани, МХБ-тэй хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулсан 72 компани, төлбөр тооцоо гүйцэтгэгч банктай гэрээ байгуулсан 57 компани, барьцаа хөрөнгө байршуулсан 53 компани тус тус байгаа бөгөөд Монголын хөрөнгийн биржийн шинэ систем, дүрэм журмын дагуу тавигдаж буй шаардлагыг хангасан брокер дилерийн компанийн тоо нэгээр нэмэгдэж нийт 51 компани арилжаанд оролцох эрхтэй боллоо.

Мэдээний тойм:

- Лондонгийн хөрөнгийн биржийн Академийн сургалт 2013 оны 1-р сарын 14-18-ны өдрүүдэд Лондон хотноо зохиогдоно.
- ”Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгалаа.
- Арилжаанд оролцох эрхтэй компанийн тоо 51-д хүрлээ
- Зах зээлийн мэдээ
- Бүртгэлтэй компанийн танилцуулга - ”Тавантолгой” ХК

TOP-20 индексийн үзүүлэлт /сүүлийн 2 долоо хоногт/



Зах зээлийн мэдээ

Монголын хөрөнгийн бирж

2 долоо хоногийн:

Арилжигдсан ширхэг 419.7 мянга
Арилжигдсан дүн 176.2 сая.төг
Арилжигдсан компанийн тоо 62

Хамгийн их өсөлттэй:

Хурх гол /HRH/ +15.0%
Эрдэнэт хүнс /TAS/ +14.9%
Нийслэл өргөө /NUR/ +14.9%

Хамгийн их бууралттай:

Эрээн цав /ECV/ -38.2%
Хангал /HGL/ -27.7%
Дорнод худалдаа /DES/ -27.7%

2012 оны 11 сарын 05-наас 2012 оны 11 сарын 16-ны хооронд нийт 9 удаагийн арилжаа явагдаж, 62 компанийн 176.2 сая төгрөгийн үнийн дүн бүхий 419.7 мянган ширхэг хувьцаа арилжсан байна.

Уг хугацаанд хамгийн идэвхтэй арилжигдсан компани нь 'Таван толгой' ХК /34.8 сая.төг/, 'АПУ' ХК /22.5 сая.төг/, 'Гермес центр' ХК /20.4 сая.төг/ байсан байна.

Зах зээлийн үнэлгээ:

TOP-20 индексийн өөрчлөлт:

1,607.8 тэрбум.төг
15,435.00 / -3.41%

Индекс:

Вебсайт:

TOP-20
www.mse.mn

Энэ удаагийн дугаараас эхлэн, гишүүн компаниудын хийсэн, МХБ-д бүртгэлтэй компаниудын судалгааг и-сонингоороо дамжуулан хүргэх болсныг дуулгахад таатай байна. Энэхүү судалгаа нь уншигчдад зөвхөн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд Монголын хөрөнгийн биржийн зүгээс мэдээллийн үнэн зөвийг шалгаагүй тул уг мэдээллийг ашигласнаар уншигчдад учирч болох аливаа санхүүгийн хохирлыг Монголын хөрөнгийн бирж хариуцахгүй болохыг анхаарна уу.

2012.11.14 МХБ Символ/Код: TTL/458

“Таван толгой” ХК

Хувьцааны мэдээлэл	
Ханш, төг₮	8,070
Ханш, ам.долл\$	5.8
Дээд ханш, төг	14,390
52 д.х хэлб, төг	4,700-14,390
33Үнэл, тб.төг	425.0
33Үнэл, сая.ам.долл	304.4
Өдр.дундаж гүйлгээ ам.долл 52 д.х	6.4K
Зах зээлд чөлөөт хөрвөх хувь, %	4%
Жилийн эхнээс одоог хүртэлх өсөлт бууралт, %	-27%

Санхүүгийн үзүүлэлтүүд	
Нийт ашиг, 2010А	63.1%
Нийт ашиг, 2011А	54.6%
ХТЭӨА-ын маржин, 2010А	62.8%
ХТЭӨА-ын маржин, 2011А	54.1%
ЭҮ/Нөөц, ам долл/тонн	4.7
Ногдол ашгийн өгөөж, 2010А	18%

Хувьцааны ханш, 000₮



Эх сурвалж: Bloomberg

Компанийн тухай товчхон


Таван Толгой ХК (TTL) нь МХБ-д бүртгэлтэй 54.6%, 41,3%-ийн нийт ба цэвэр ашгийн маржинтай дэлхийд хамгийн өндөр ашгийн маржинтай коксжих нүүрсний олборлогч бөгөөд дэлхийн хэмжээнд хамгийн хямд зардлаар коксжих нүүрс олборлодог уурхайн нэг ба ердөө нэгж уурхайн зардал ойролцоогоор тоннд \$10, олон улсын дунджаас ойролцоогоор 5.5 дахин бага юм. 2010 оны хувьд коксжих нүүрсний экспортоор Монгол Улсын тэргүүлэгч компани байсан ба МХБ-д бүртгэлтэй хамгийн том зах зээлийн үнэлгээтэй компани юм.

“Таван толгой” ХК бол дэлхийн хэмжээнд хамгийн бага нэгж олборлолтын зардалтай ба хамгийн өндөр ашигт ажиллагаатай Хятад улсын хилтэй ойрхон оршдог чухал давуу талтай коксжих нүүрс олборлогч юм. Таван толгойн хөрс хуулалтын коэффициент 3.1км/тонн, олборлолтын тааламжтай нөхцөл болон Хятадын хилтэй ойр зэрэг хүчин зүйлс нь уг уурхайг ашгийн өндөр хувьтай ажиллах нөхцлийг бүрдүүлдэг байна. Компани нь дэлхийн хэмжээнд хамгийн хямд зардлаар коксжих нүүрс олборлодог уурхайн нэг бөгөөд нэгж уурхайн зардал ойролцоогоор тоннд ердөө \$10, олон улсын дунджаас ойролцоогоор 5.5 дахин бага ба уурхайн амнаас борлуулж байгаа үнэ нь Хятад улсын зах зээлийн үнэ болон зах зээлийн спот үнээс маш хямдхан юм. Спот зах зээлийн үнээс хямд байгаа нь дараах хүчин зүйлсээс хамааран буурах магадлалтай. 1) Хятадын нүүрсний эцсийн хэрэглэгчид Таван толгойн нүүрсний чанарыг сайн таних, 2) агуулах болон тээвэр зуучийн хязгааралттай байдлууд багасах тусам тээвэрлэгчид, зуучлагчдын маржин буурах магадлалтай, 3) Хятад улс НӨАТ болон портуудын тарифаа бууруулах магадлалтай.

Компанийн лицензийн талбай нь эдийн засгийн хамгийн ашигтай хэсэгт бөгөөд ашиглалтанд ороогүй дэлхийд хамгийн том коксжих нүүрсний орд болох Таван Толгойн коксжих нүүрсний орд газрын хамгийн бага хөрс хуулалтын коэффициенттэй хэсэгт байрладаг юм. Таван Толгой ХК-ийн лиценз нь асар том Таван Толгойн орд газрын зүүн Цанхийн хамгийн өндөр чанартай, хамгийн бага хөрс хуулалтын коэффициенттэй хэсэгт 169 га газрыг хамардаг. Уг компани 2011 онд лицензийн бүс нутагтаа 14 дооног өрөмдлөгийн ажил хийсэн ба нарийвчилсан нөөцийн үнэлгээ ба лабораторийн мэдээлэл хэдэн сарын дараа бэлэн болохоор хүлээгдэж байна. Компанийн удирдлагын үзэж буйгаар тооцоолж буй коксжих нүүрсний нөөцөө 90 сая тонн гэж үзэж байна. Таван Толгойн нүүрсний чанарын үзүүлэлтүүдийг дурьдвал нүүрсний илчлэг нь дунджаар 6500-7500ккал/кг, үнслэг 20%, чийглэг 8.5%. Таван Толгойн нөөцийн 75% гаруй нь коксжих ба 25%-аас бага нь эрчим хүчний нүүрс юм (үндсэндээ 100% коксжих нүүрс).

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц: Таван Толгой ХК-ийн 51%-ийг Өмнөговь аймгийн орон нутгийн Засаг захиргаа эзэмшдэг бөгөөд бусад нь хувийн эзэмшилд байдаг. Таван Толгой ХК-ийн томоохон хувийн хувьцаа эзэмшигчдэд Улаанбаатар хотод байрлах Ажнай Корпораци 24%-ийг, Монголын ноолууран эдлэлийн үйлдвэрлэлээр тэргүүлэгч Ээрмэл ХК 21% бөгөөд үлдсэн 4%-ийг МХБ дээрхи бусад жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшдэг.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



Эх сурвалж: Компанийн мэдээлэл, Рескапийн дүгнэлт

Компанийн тойм

Таван Толгой (ТТ) нэрээр нэршсэн 2 компани байдаг. Нэг нь 6.4 тэрбумын нөөцтэй 100% төрийн эзэмшилд байдаг “Эрдэнэс Таван Толгой МГЛ” байдаг бол нөгөө нь МХБ-д бүртгэлтэй Таван Толгой ХК (ТТЛ) юм.

Таван Толгой нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1966 оны тогтоолоор тус орд газрыг улсын болгож, Аж үйлдвэрийн яаманд шилжүүлснээр анх 8 хвний бүрэлдэхвэнтэй, 3000 тонн нүүрс олборлон борлуулах улсын төлөвлөгөөтэйгөөр үйл ажиллагаагаа эхэлж байсан бөгөөд 1967 онд бие даасан улсын эзэмшлийн нүүрсний уурхай болсон.


1994 оны 12 сарын 5-нд төрийн өмч давамгайлсан Таван Толгой ХК болсон. Таван Толгой ХК нь Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байршдаг. Улаанбаатар хотоос 550 км зайд оршдог.

Өнөөдөр, “Таван Толгой” ХК нь МХБ дээр зах зээлийн үнэлгээгээр хамгийн том компани бөгөөд бүтээгдэхүүний хэмжээгээр 2010 онд 5 сая тонн гаран кокежих нүүрс олборлосон Монголын хамгийн том нүүрсний уурхайнуудын нэг юм. 2004 онд Хятадын харилцагчтай нүүрс экспортлох гэрээ байгуулсан бөгөөд тэр үеэс хойш Хятад улс руу экспортлох нүүрсний хэмжээ маш ихээр нэмэгдсээр байна.

Компани нь Таван Толгой Транс, Монгол Транс, Хурд гэх мэт 13 гаруй тээврийн компанитай хамтран ажилладаг бөгөөд Хятад руу нүүрс тээвэрлэдэг эсвэл борлуулахад зуучлагч бусад компаниуд нь Хятад руу дамжуулан борлуулсаар байна. 2010 онд 5 сая тонныг олборлож, дийлэнх хувийг Хятад руу гаргасан байна. Тус компани нь дотоодын зах зээлд төрийн зохицуулалтын улмаас маш хямдхан буюу тонныг нь 6.5 ам.дол-оор борлуулдаг ба экспортод түүхий нүүрсийг ойролцоогоор тонныг нь 49 ам.дол-оор борлуулж байна.

Тус компани нь нийт 200 гаруй ажилчид, хэд хэдэн гэрээт уурхайчидтай ажиллаж байна. Уг компани уурхайн талбар дээр ажиллаж буй тоног төхөөрөмжийн ¼-аад хувийг эзэмшдэг ба ¾ нь гэрээт уурхайчдын тоног төхөөрөмж эзэлдэг байна.

Таван толгойн уурхай




Орд газрын тойм

Таван Толгой орд газар нь Монголын хамгийн том нүүрсний орд газар ба коксжих, эрчим хүчний нүүрсний 7.5 тэрбумын нөөцтэй дэлхийн хамгийн том 10 орд газрын нэг юм. Таван Толгойн нүүрсний сав газарт Эрдэнэс МГЛ (6 уул уурхайн лиценз), Монголиа Майнинг (1 уул уурхайн лиценз), Морил Луу (1 уул уурхайн лиценз), Брод (1 уул уурхайн лиценз), Дайцуки (1 уул уурхайн лиценз) ба Таван Толгой ХК 2 уул уурхайн лицензийг хэсэгчлэн эзэмшдэг (4 ба 8-аар амнууд).

Таван Толгойн 2 олборлолтын лиценз нь Таван Толгой орд газрын Зүүн Цанхид 169 га талбайг хамран байрладаг.

Уг компани 2011 онд лицензийн бүс нутагтаа 14 цооног өрөмдлөгийн ажил хийсэн ба нарийвчилсан нөөцийн үнэлгээ ба лабораторийн мэдээлэл хэдэн сарын дараа бэлэн болохоор хүлээгдэж байна. Компанийн удирдлагын үзэж буйгаар тооцоолж буй коксжих нүүрсний нөөцөө 90 сая тонн гэж үзэж байна. Таван Толгойн нүүрсний чанарын үзүүлэлтүүдийг дурьдвал нүүрсний илчлэг нь дундажаар 6500-7500ккал/кг, үнслэг 20%, чийглэг 8.5%. Таван Толгойн нөөц нь 75% гаруй нь коксжих ба 25%-аас бага нь эрчим хүчний нүүрс юм (бараг 100% коксжих нүүрс). Гэвч албан ёсны үнэлгээгээр Зүүн Цанхийн блокийн нөөцийн 78% нь коксжих ба бусад нь өндөр чанарын эрчим хүчний нүүрс юм. Норвестийн урьдчилсан үнэлгээгээр Таван Толгой орд газар нь ЖОРК-оор нийтдээ 7.5 тэрбумын коксжих ба эрчим хүчний нүүрсний нөөцтэй гэж тогтоогдоод байгаа ба Таван Толгой ХК-ийн эзэмшил доорх #287, #11945 олборлолтын лиценз буюу 4 ба 8-р амуудын хувьд 70% нь буюу 60.3 сая тонн нь коксжих нүүрс, 82% нь буюу 78.8 сая тонн нь коксжих нүүрс гэж тус тус үнэлсэн байна.



Орлогын тайлан, сая.төг	2010A	2011A
Орлого (цэвэр)	170,468.8	194,004.5
Үйл ажиллагааны зардал	(62,965.0)	(88,055.6)
Нийт ашиг	107,503.8	105,949.0
<i>Нийт ашгийн маржин (%)</i>	<i>63.1%</i>	<i>54.6%</i>
Удирдлагын зардал	--	--
Ерөнхий удирдлага болон борлуулалтын	(502.2)	(948.4)
Бусад зардал	(28.9)	--
Хайгуулын зардал	--	--
Хүү, татвар, элэгдлийн өмнөх орлого	106,972.6	105,000.6
<i>Хүү, татвар, элэгдлийн өмнөх орлогын маржин</i>	<i>62.8%</i>	<i>54.1%</i>
Элэгдэл	(123.0)	(146.4)
Хорогдол	--	--
Хүү, татварын өмнөх орлого	106,849.7	104,854.2
<i>Хүү, татварын өмнөх орлогын маржин</i>	<i>62.7%</i>	<i>54.0%</i>
Хүүгийн орлого (зардал)	--	--
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг(алдагдал)	(4,339.9)	1,179.3
Үйл ажиллагааны ашиг	102,509.8	104,854.2
Орлогын татварын зардал	(25,984.1)	(25,975.5)
Татварын дараах ашиг	76,525.7	80,058.0
Цөөнхөд ноогдох хувь	--	--
Цэвэр ашиг	76,525.7	80,058.0
<i>Цэвэр ашгийн маржин</i>	<i>44.9%</i>	<i>41.3%</i>
Баланс, сая.төг	2010A	2011A
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	92,254.5	33,154.1
Дансны авлага	17,713.4	69,658.1
Урьдчилж төлсөн зардал	680.5	4,191.2
Бараа материал	1,176.5	1,737.6
Бусад эргэлтийн хөрөнгө	--	44.8
	111,824.9	108,785.7
Үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж	6,668.7	6,565.5
Биет бус хөрөнгө	68.3	146.7
Хөрөнгө оруулалт	--	--
Бусад хөрөнгө	--	--
Нийт хөрөнгө	118,561.9	115,497.9
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	2,961.7	5,278.9
Богино хугацаат зээл	--	--
Бусад өглөг	15,938.7	543.4
Нийт богино хугацаат өр төлбөр	18,900.4	5,822.3
Урт хугацаат өр төлбөр	--	--
Бусад урт хугацаат өглөг	--	--
Хойшлогдсон орлогын татвар	--	--
Нийт урт хугацаат өр төлбөр	18,900.4	5,822.3
Цөөнхийн хувь оролцоо	--	--
Эзэмшигчдийн өмч		
Энгийн хувьцаа	94.5	94.5
Хуримтлагдсан ашиг	99,056.0	109,070.1
Бусад	511.0	511.0
Эзэмшигчдийн өмчийн дүн	99,661.5	109,675.6
Нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчийн дүн	118,561.9	115,497.9